

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

ДОТООД АЛБАН БИЧИГ

Дугаар: 09/04

Огноо: 2024.01.23

Хаанаас: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс

Хаана: Санхүүгийн хэлтэс болон Боомт, орон нутаг дахь зохион байгуулалтын нэгжийн дарга нарт

Утга: Зөвлөмж хүргүүлэх тухай

Төв болон боомт, орон нутаг дахь нэгжүүдийн 2023 оны 4 дүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын хяналт шалгалтын дагуу дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1.1. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд байршуулах, байршуулж буй мэдээллийн чанар, агуулга, үнэн зөв, иж бүрэн байдалд анхаарал хандуулж ажиллах;


1.2. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, тушаалыг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

1.3. Удирдлагаас хүргүүлсэн үүрэг чиглэл, албан даалгавар, дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

1.4. Төсвийн шууд захирагчаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах;

1.5. Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж заасныг анхаарч ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж биелэлтийг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн дотор jargalmaa.l@immigration.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА  З.ӨНӨРСАЙХАН